

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 онд хэрэгжүүлэх  
үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

/2015 оны эхний хагас жилийн байдлаар/

Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээ /гарц/-ний шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшин	Биелэлт
1	2	3
<b>Нэг. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний цогц бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд</b>		
<b>1.1.“Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд Үл хөдлөх эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлнэ: /5.3.5-ын Стратегийн зорилт 4/</b>		
<p>1.1.1. ММСС-ийн “Хөрөнгийн эрхийн төсөл” хэрэгжээгүй үлдсэн 13 аймгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цаасан суурьт нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ. <i>2015 он, жилдээ</i></p>	<p>-ММСС-ийн хөрөнгийн эрхийн төсөл хэрэгжээгүй Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Увс, Хөвсгөл, Сүхбаатар, Сэлэнгэ /Мандал, Сайхан бүсээс бусад/ аймгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цаасан суурьт нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.</p>	<p>Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Увс, Хөвсгөл, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх зорилгоор “Ухаалаг засаг” төсөлд уг арга хэмжээг тусган, төслийг санхүүжүүлж буй Дэлхийн банкны төлөөлөлтэй тус газрын удирдлагууд уулзалт зохион байгуулсан. Уг төслийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2015 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар тус тус оруулж, хэлэлцүүлэн дэмжээд байна. Зарим аймаг, орон нутгийн удирдлагаас шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж байна.</p> <p>Тухайлбал: Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тухайн аймаг, орон нутгийн санхүүжилтээр эхлүүлж, ePRS системийг нэвтрүүлэн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж эхлээд</p>

		<p>байна. Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явц 99.4%-тай явагдаж байна. Мөн Баян-Өлгий, Өмнөговь аймгийн орон нутгийн удирдлагаас тухайн аймгуудын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлээд байна.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>1.1.2. Бүртгэлийн анхан шатны нэгжид эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>- Хүн амын төвлөрөл ихтэй зарим сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Сэлэнгэ аймгийн Мандал бүс /Мандал, Баянгол сум/, Сайхан бүс /Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сум/, Завхан аймгийн Тосонцэнгэл сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Мөн Өмнөговь аймгийн Даланзадгад, Төв аймгийн Лүн суманд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хийж байна.</p> <p>Бусад сумын иргэдэд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сумын улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн анхны бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтыг суманд хүлээн авах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, эхний хагас жилийн байдлаар нийт 6794 мэдүүлгийг суманд хүлээн авсан байна.</p> <p><b>Биелэлт: 70%</b></p>
<p><b>1.2. “Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна” зорилтын хүрээнд Төрийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, төрийн бүртгэлд бүртгүүлснийг батлах баримт бичгийг компьютерт уншигдахаар болгон, бусад төрлийн цахим баримт бичигтэй хоршин хэрэглэдэг болгоно: /7.2-ын Стратегийн зорилт 5/</b></p>		
<p>1.2.1 “Бүртгэл, мэдээллийн цахим архив” төслийн хүрээнд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран Иргэний баримтын архивын цаасан суурьт баримтыг цахимжуулах ажлыг бүрэн дуусгаж, хэрэглээнд нэвтрүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Иргэний бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, бүрэн дуусгана.</p>	<p>Иргэний баримтын архивын санд хадгалагдаж байгаа цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байх бөгөөд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн болон хувийн хэргийн сангийн цахимжуулалт 61.51%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Цахимжсан хувийн хэргийн материалаас “Мэдээлэл удирдах систем”-ийг ашиглан архивын лавлагаа, мэдээллийг түргэн шуурхай олгож байна.</p> <p><b>Биелэлт: 61.51%</b></p>
<p>1.2.2. Бүртгэлийн үйлчилгээнд цахим хэлбэрээр хамрагдах боломжийг</p>	<p>-ТҮЦ машинаар үзүүлэх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТҮЦ машинаар иргэний бүртгэлийн 6 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн</p>

<p>нэмэгдүүлнэ. 2015 он, жилдээ</p>		<p>эрхийн бүртгэлийн 1 төрлийн лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн 2 төрлийн лавлагаа, хаяж гээгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан иргэний үнэмлэх дахин авах хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах гэсэн нийт 10 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. ТҮЦ машинаар тус газрын 2 төрлийн үйлчилгээг нэмж үзүүлэх талаар Хууль зүйн яам, МШХХТГ, “Үндэсний дата төв”-д санал хүргүүлээд байна. <b>Биелэлт: 50%</b></p>
<p>1.2.3. Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн баримтын цахимжсан санг бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглана. 2015 он, жилдээ</p>	<p>-Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн баримтын цахимжсан санг бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээнд бүрэн нэвтрүүлнэ.</p>	<p>Иргэний баримтын архивт хадгалагдаж буй архивын цаасан суурьт эх нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, “Мэдээлэл удирдах систем”-ийг ашиглалтанд оруулснаар цахимжсан санг бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээнд ашиглаж байна. Нийслэлийн 9 дүүрэг, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймаг, Сэлэнгэ аймгийн Сайхан Мандал бүсийн 7 суманд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээнд цахим мэдээллийн санг бүрэн ашиглаж, бүртгэлийн үйл ажиллагааг цахим санд хөтлөн явуулж байна. <b>Биелэлт: 40%</b></p>
<p>1.2.4. Бүртгэлийн лавлагаа мэдээллийн үйлчилгээнд хурууны хээ, цахим үнэмлэхний хэрэглээг нэвтрүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Бүртгэлийн лавлагаа мэдээллийн үйлчилгээнд хурууны хээ, цахим үнэмлэхний хэрэглээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Хурууны хээ болон цахим иргэний үнэмлэх ашиглан бүх аймаг, дүүрэг, онлайн сүлжээнд холбогдсон хороодоос иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн 10 төрлийн лавлагаа олгох системийг нэвтрүүлээд байна. <b>Биелэлт: 90%</b></p>
<p><b>1.3. Бүртгэл, мэдээллийн тогтолцоог богино хугацаанд бүхэлд нь боловсронгуй болгоно: /7.2-ын Стратегийн зорилт 5/</b></p>		
<p>1.3.1. Интернетэд суурилсан Хуулийн этгээдийн бүртгэл мэдээллийн системийг бий болгоно. 2015 он, жилдээ</p>	<p>-Шинээр батлагдсан хуульд нийцүүлэн програм хангамжийг боловсруулж, хөгжүүлнэ.</p>	<p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2015 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх портал сайт болон хуулийн этгээдийн нэрийг онлайнаар шинээр авах, хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үйлчилгээний</p>

		<p>дарааллыг урьдчилан захиалах хүсэлт хүлээн авах, хуулийн этгээдийн гэрчилгээг онлайнаар харах агуулга бүхий үйлчилгээний вэб порталыг бий болгох зорилгоор “Инносолюшн” ХХК-тай хамтран ажиллаж, төрийн үйлчилгээний вэб порталын системийн туршилт болон нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж дуусган Тагнуулын ерөнхий газрын Кибер аюулгүй байдлын газраас зөвшөөрөл авч хэрэглээнд нэвтрүүлээд байна.</p> <p>Мөн “Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн систем” програм хангамжийн хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулж, холбогдох албан хаагчдад хүргүүлэн, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p><b>Биелэлт: 100%</b></p>
<p>1.3.2. Нийслэлийн бүртгэлийн анхан шатны нэгжээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. 2015 он, жилдээ</p>	<p>-Хороодыг мэдээллийн нэгдсэн онлайн системд холбож, анхан шатны нэгжийн түвшинд иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, УБЕГ-ын даргын хооронд 2014-03-25-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, энэхүү санамж бичгийн хүрээнд иргэний бүртгэлийн онлайн сүлжээнд нийт 83 хороог холбож, холбогдох тохиргоог хийн, шилжилт хөдөлгөөний, гэрлэсний, гэрлэлт цуцалсны /шүүхийн журмаар/, гэрлэлт сэргээсний, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ дахин олголтын, иргэний үнэмлэхийн, оршин суугаа хаягийн лавлагаа олгох зэрэг үйлчилгээг хорооны түвшинд үзүүлж байна.</p> <p>Хурууны хээ болон цахим иргэний үнэмлэх ашиглан бүх аймаг, дүүрэг, онлайн сүлжээнд холбогдсон хороодоос иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн 10 төрлийн лавлагаа олгох системийг нэвтрүүлээд байна.</p> <p><b>Биелэлт: 70%</b></p>
<p>1.3.3. Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэх ажлыг эхлүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэнэ.</p>	<p>“Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэх журам”-ын төслийг боловсруулан байгууллагын <a href="https://burtgel.gov.mn/">https://burtgel.gov.mn/</a> цахим хуудаст байршуулан, иргэд олон нийтээс санал авч байна.</p> <p>Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг хэрэгжиж эхэлснээр төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэх боломж бүрдэнэ.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>

<p>1.3.4. Улсын бүртгэлийн байгууллагаас олгох бичиг баримтыг шуудангийн сүлжээгээр дамжуулан иргэнд гараас гарт хүргэх үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-“Монгол шуудан” ТӨХК-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлж “Гараас гарт” үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, лавлагааг иргэнд хаягаар гараас гарт хүргэнэ.</p>	<p>“Монгол шуудан” ТӨХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Гараас гарт хүргэх” шуудангийн үйлчилгээг өргөжүүлж, Монгол Улсын Үндэсний энгийн гадаад паспортоос гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, холбогдох баримт бичгийг шуудангийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэдэг болсон. Эхний хагас жилийн хугацаанд нийт 6703 иргэний гадаад паспорт, 383 хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, холбогдох баримт бичгийг иргэн, хуулийн этгээдийн хаягаар шуудангаар хүргээд байна. Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, лавлагааг “Гараас гарт хүргэх” шуудангийн үйлчилгээгээр дамжуулан иргэн хуулийн этгээдэд хүргүүлэх талаар “Монгол шуудан” ТӨХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. <b>Биелэлт: 70%</b></p>
<p>1.3.5. Цахим үнэмлэхний ухаалаг хэрэглээг нэмэгдүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Хаягийн шилжилт хөдөлгөөнөөс хамаарч цахим үнэмлэхний хаяг солигдон, олон хэвлэгддэг байдлыг халж, хаягийг цахим үнэмлэхэд далд бичих үйлчилгээг нэвтрүүлнэ.</p>	<p>Иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд шилжилт хөдөлгөөний мэдээллийг бичих, иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойгоос бичвэр, зурган мэдээллийг унших боломжтой шийдлийг боловсруулан хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. <b>Биелэлт: 85%</b></p>
<p>1.3.6. Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг иргэдэд мессежээр хүргэж эхэлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг иргэдэд мессежээр хүргэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Төв, Увс, Өвөрхангай зэрэг нийт 7 аймагт бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг иргэдэд мессежээр хүргэх үйлчилгээг нэвтрүүлээд байна. <b>Биелэлт: 80%</b></p>

### Хоёр. Хууль зүйн салбарын нээлттэй бодлогын хүрээнд

#### 2.1. “Хууль зүйн салбарын нээлттэй бодлого” баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллана:

<p>2.1.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг олон нийтэд вэб сайт ба бусад арга хэрэгслээр тайлагнаж ажиллана. 2015 он, жилдээ</p>	<p>- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг олон нийтэд вэбсайт ба бусад арга хэрэгслээр тайлагнана.</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв, санхүүгийн, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж, хууль тогтоомжид заасан мэдээ, мэдээллийг байгууллагын <a href="https://burtgel.gov.mn">https://burtgel.gov.mn</a> цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулан, шинэчилсэн. Эхний хагас жилийн байдлаар цахим хуудсанд 322</p>
---	---	---

		<p>мэдээллийг шинээр байршуулж, 92 мэдээллийг шинэчлэн байршуулсан байна.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>2.1.2. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэх, сурталчилах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана.</p> <p>2015 он, жилдээ</p>	<p>-Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилна.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлж буй үйлчилгээ, цаг үеийн үйл явдлын мэдээ, мэдээллийг нийт 41 хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 82 удаагийн сурталчилгааг телевиз, мэдээллийн сайт, өдөр тутмын сонингоор дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна телевиз, радиогийн нийт 15 нэвтрүүлэгт оролцсон байна.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>2.1.3. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж, сурталчилна.</p> <p>2015 он, жилдээ</p>	<p>-Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг цахим хуудаст тухай бүр байршуулна.</p>	<p>Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг байгууллагын цахим хуудаст тухай бүр байрлуулан олон нийтэд мэдээлж, сурталчилсан.</p> <p>Цахим хуудсанд 1 хууль, Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан 4 журам, УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан 7 журмыг шинэчлэн байршуулсан байна.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>2.1.4. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг вэб сайтаар дамжуулан мэдээлж ажиллана.</p> <p>2015 он, жилдээ</p>	<p>-Байгууллагын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг вэб сайтаар дамжуулан тогтмол мэдээлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Байгууллагын <a href="https://burtgel.gov.mn">https://burtgel.gov.mn</a> цахим хуудсанд шилэн дансны цэсийг байршуулан Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д заасан санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах мэдээ, мэдээллийг батлагдсан загвар маягтын дагуу цахим хуудас болон мэдээллийн самбараар нийтэд ил тод мэдээлж ажилласан.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>2.1.5. Тус байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, тайланг Хууль зүйн яаманд хүргүүлж, цахим хуудсанд байршуулна.</p> <p>2015 он, жилдээ</p>	<p>-Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, тэдгээрийг шийдвэрлэсэн байдлын талаарх тайланг сар тутам Хууль зүйн яаманд хүргүүлж, цахим хуудсанд байршуулна.</p>	<p>Тус газар нь иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Засгийн газрын <a href="http://www.zasaq.mn">www.zasaq.mn</a> цахим хуудас дахь “11-11 мэдээллийн төв”, тус газрын <a href="https://burtgel.gov.mn/">https://burtgel.gov.mn/</a> цахим хуудас дахь “Зочны дэвтэр”, “Улсын бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890” дугаарын утас, “Иргэнд ээлтэй утас: 70122014”, “Онлайн лавлах 1800-1890” мессенжер, Фэйсбүүк, өргөдөл, гомдол хариуцсан ажилтан амаар болон бичгээр, санал, хүсэлтийн хайрцаг, дэвтрээр тус тус хүлээн авч түргэн</p>

		<p>шуурхай шийдвэрлэж байна.</p> <p>Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийг шийдвэрлэсэн байдлын талаарх тайланг сар тутам Хууль зүйн яаманд хүргүүлж, байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>2.1.6. Тогтмол ажиллагаатай салбар, хороодын үйл ажиллагааны талаар цахим хуудсанд тухай бүр мэдээлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Төрийн албаны салбар зөвлөл, даргын зөвлөл, ёс зүйн хорооны хуралдааны шийдвэрийг цахим хуудсанд мэдээлдэг болсон байна.</p>	<p>Байгууллагын <a href="https://burtgel.gov.mn/">https://burtgel.gov.mn/</a> цахим хуудсанд “Төрийн албаны зөвлөлийн УБЕГ-ын дэргэдэх салбар зөвлөл”, “УБЕГ-ын дэргэдэх ёс зүйн хороо”, “УБЕГ-ын хүний нөөц” цэсийг шинээр үүсгэж, холбогдох мэдээ, мэдээлэл, хуралдааны шийдвэрийг цахим хуудсаар мэдээлдэг болсон.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p><b>Гурав. Улсын бүртгэлийн хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох</b></p>		
<p><b>3.1. Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.</b></p>		
<p>3.1.1. Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар батлуулах ажлын бэлтгэлийг ханган ажиллана. 2015 он, жилдээ</p>	<p>-Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар батлахтай холбогдуулан, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын албан хаагчид орж ажиллан, шаардлагатай мэдээ мэдээллээр хангана.</p>	<p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус газраас боловсруулж, Хууль зүйн яам болон УИХ-ын Хууль зүйн байнгын хороон дээр байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд тус газрын холбогдох албан хаагчид ажиллаж, уг хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурлаар баталсан.</p> <p>“Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг тус газраас боловсруулж,</p> <p>Хууль зүйн яаманд хүргүүлсэн бөгөөд Хууль зүйн яам болон УИХ-ын Хууль зүйн байнгын хороон дээр байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд тус газрын холбогдох албан хаагчид ажиллаж, уг хуулийг Улсын Их Хурлаас анхны хэлэлцүүлгээр хэлэлцүүлэхээр дэмжээд байна.</p> <p>Иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус газраас боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн бөгөөд Хууль зүйн яаманд байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд тус газрын</p>

		холбогдох албан хаагчид ажиллаж, шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. <b>Биелэлт: 60%</b>
3.1.2. Сүлжээгээр дамжих мэдээллийн ангилал тогтоох журмыг боловсруулан, батална. <i>2015 он, жилдээ</i>	-Журмыг Даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, батална.	“Сүлжээгээр дамжих мэдээллийн ангилал тогтоох журам”-ын төслийг боловсруулж байна. <b>Биелэлт: 30%</b>
3.1.3. Мэдээллийн технологи мэдээллийн сангийн аюулгүй байдалд анхаарч, энэ чиглэлээр тодорхой ажлуудыг төсөв санхүүтэй уялдуулан зохион байгуулна. <i>2015 он, жилдээ</i>	-Мэдээллийн технологи, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	Мэдээллийн технологи, мэдээллийн сангийн аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор Иргэний цахим үнэмлэхийн бэлдэц, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хадгалах төхөөрөмжийн багтаамжийг нэмэгдүүлэх, Иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн хэвийн ажиллагааг хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. <b>Биелэлт: 80%</b>
3.1.4. Шинээр батлагдан гарсан буюу нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжтой уялдуулан дагаж мөрдөх дүрэм, журмыг тухай бүр шинэчлэн боловсруулна. <i>2015 он, жилдээ</i>	- Шинээр батлагдан гарсан буюу нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжтой уялдуулан холбогдох дүрэм, журмыг тухай бүр шинэчлэн боловсруулна.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдсантай холбогдуулан тус газраас дараах журмын төслийг боловсруулан Хууль зүйн сайдаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалаар “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”,</li> <li>• Хууль зүйн сайдын 2015 оны А/40 дүгээр тушаалаар “Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”,</li> <li>• Хууль зүйн сайдын 2015 оны А/41 дүгээр тушаалаар “Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам”;</li> <li>• Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалаар “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”.</li> </ul> Мөн УБЕГ-ын даргын 2015 оны 335 дугаар тушаалаар “Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын 2004 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” /Хуулийн этгээдийн улсын

		бүртгэлийн жагсаалт хөтлөх журам/ 20 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлэн, Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 220 дугаар тогтоолоор хүчингүй болгуулсан. <b>Биелэлт: 50%</b>
3.1.5. Улсын бүртгэлийн хяналтын үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. <i>2015 он, жилдээ</i>	-Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хяналт шалгалтын зохицуулалтын талаар судалгаа хийж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар холбогдох арга хэмжээг авч ажиллана.	“Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам”-ын нэмэлт, өөрчлөлтийн талаарх санал, судалгааг төв, орон нутгийн хяналтын улсын байцаагч нараас авч нэгтгэн, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж байна. <b>Биелэлт: 50%</b>
<b>Дөрөв. Байгууллагын стратеги үйл ажиллагаа, бодлого төлөвлөлт</b>		
<b>4.1. Байгууллагын стратеги үйл ажиллагаа, бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлнэ:</b>		
4.1.1. Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн мэдээ, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн гаргаж, холбогдох газарт хүргүүлнэ. <i>2015 он, жилдээ</i>	-Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн мэдээ, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн гаргаж, холбогдох газарт хүргүүлнэ.	Тус газарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтийн тайлан, УБЕГ-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт зэргийг 2015 оны эхний 5 сарын байдлаар нэгтгэн гаргаж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайлан, Холбогдох эрх зүйн актын биелэлтийг 2015 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн. <b>Биелэлт: 50%</b>
4.1.2. Байгууллагын цахим хуудасны програм хангамжийг өөрчлөн дэвшилтэт шинэ програм хангамжаар шинэчлэн боловсруулна. <i>2015 он, жилдээ</i>	-Байгууллагын цахим хуудасны онлайн сүлжээг портал програмтай холбож, мэдээ мэдээллийг тухай бүр шуурхай авах боломжоор хангана.	Байгууллагын <a href="https://burtgel.gov.mn/">https://burtgel.gov.mn/</a> цахим хуудасны програм хангамжийг өөрчлөн дэвшилтэт шинэ програм хангамжийг шинэчлэн боловсруулахаар бэлтгэж байна. <b>Биелэлт: 20%</b>
4.1.3. Иргэний бүртгэлийн онлайн системийн хурдыг нэмэгдүүлнэ. <i>2015 он, жилдээ</i>	-Иргэний бүртгэлийн онлайн системийг өндөр хурдны оптик төхөөрөмжид суурилсан Cluster-т шилжүүлэн, хэвийн тогтвортой ажиллагаатай болгоно.	Иргэний бүртгэлийн онлайн системийг өндөр хурдны оптик төхөөрөмжид суурилсан Cluster-т шилжүүлэн, хэвийн тогтвортой ажиллагаатай болгохтой холбоотой тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан, туршилтын ажлыг эхлүүлээд байна. <b>Биелэлт: 80%</b>

<p>4.1.4. 2014 оны төв болон орон нутгийн төрийн сангийн нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж холбогдох газарт хүргүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-2015 оны төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог хангаж ажиллана. -Байгууллагын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитаар баталгаажуулж, холбогдох газарт хүргүүлнэ.</p>	<p>2015 оны төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог ханган ажиллаж байна. Байгууллагын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ерөнхий газар, аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсийн хэмжээнд нэгтгэн гаргаж, аудитаар баталгаажуулж, Хууль зүйн яаманд хугацаанд нь хүргүүлж ажилласан. <b>Биелэлт: 75%</b></p>
<p>4.1.5. Цахим хэрэглээг нэвтрүүлэх замаар байгууллагын урсгал зардлыг бууруулах тодорхой үр дүнтэй ажлыг зохион байгуулна. 2015 он, жилдээ</p>	<p>-Цахим хэрэглээг нэвтрүүлж, урсгал зардлыг бууруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.</p>	<p>Байгууллагын хэмжээнд нэгдсэн портал систем буюу e-Office системийг боловсруулж, гарын авлага бэлтгэн албан хаагчдад сургалт зохион байгуулсны үндсэн дээр тухайн системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. e-Office системийг улсын бүртгэлийн гадаад болон дотоод бүх сүлжээнд хэрэглэх боломжийг бүрдүүлснээр Улсын бүртгэлийн байгууллагын төвийн болон орон нутаг дахь салбар нэгжүүд хоорондоо цахим хэлбэрээр харилцаж, байгууллагын урсгал зардлыг бууруулж байна. <b>Биелэлт: 100%</b></p>
<p>4.1.6. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн ажлыг зохион байгуулна. 2015 он, жилдээ</p>	<p>-Зорилтот бүлгийн тодорхой хэсгийг бичиг баримтжуулах, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг зохион байгуулна.</p>	<p>Бүртгэлийн байгууллагын нийт албан хаагчдын дунд гал түймрийн гамшигт өртсөн зүүн 3 аймгийн ард иргэддээ туслах зорилгоор “Сайн үйлсийн аян”-г өрнүүлэн, иргэдийг бичиг баримтжуулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Эхний байдлаар 108 иргэний баримт бичгийг хэвлүүлэн иргэдэд гардуулан өгөхөд бэлэн болоод байна. Улсын бүртгэлийн үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлах, иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай үндсэн ойлголт, төрлүүд, анхаарах асуудлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн ойлголт өгөх, тэдэнд төрийн үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангахад чиглэгдсэн сургалтыг “Сэргээн Засалт, Хөгжлийн Үндэсний төв”-д 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч, Сэргээн засалт, Хөгжлийн Үндэсний төвийн 30 орчим албан хаагчид хамрагдсан. <b>Биелэлт: 70%</b></p>



		<b>Биелэлт: 100%</b>
4.2.4. Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн бүртгэлийн газар, хэлтсийн санхүүгийн болон татвар, төлбөр, хураамжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, дотоод аудит хийнэ. <i>2015 он, жилдээ</i>	-Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин, дотоод аудитын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж, үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор санал, зөвлөмж боловсруулна.	Орхон, Булган, Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, Улсын бүртгэлийн төв архивын газрын иргэний баримтын архивын цахимжуулалтын үйл ажиллагаанд “үйл ажиллагааны аудит” хийж, аудитын дүнд тухайн газар, хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж хүргүүлээд байна. <b>Биелэлт: 50%</b>
4.2.5. Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянах, илрүүлэх, эрсдлийн удирдлагын системийг хяналт, шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. <i>2015 он, жилдээ</i>	Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянах, илрүүлэх, эрсдлийн удирдлагын системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянах, илрүүлэх, эрсдлийн удирдлагын системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх судалгаа хийж байна. Нийт иргэний бүртгэлийн зөрчилтэй байж болзошгүй /Төрөлтийн бүртгэлийн ХААТР маягт мэдээллийн санд ороогүй/ 19 мянган бичлэг, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 6 төрлийн зөрчлийн талаарх жагсаалтыг гарган, архивын эх нотлох баримтай тулган шалгаж, зөрчлийг залруулах арга хэмжээг авч байна. <b>Биелэлт: 70%</b>
<b>4.3. Хүний нөөцийн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана:</b>		
4.3.1.“Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллана. <i>2015 он, жилдээ</i>	- “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллана.	“УБЕГ-ын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Тус газрын албан хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах экологийн зөв хүмүүжлийг олгох зорилгоор Эко клубыг санаачлан байгуулж, үйл ажиллагааг идэвхитэй явуулж байна.</li> <li>• Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төв аймгийн нутаг дэвсгэр болох Хөшигтийн хөндийд албан хаагчдад зуслангийн газар олгох асуудлаар аймгийн Засаг даргад хүсэлт тавин шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.</li> </ul> <b>Биелэлт: 40%</b>
4.3.2. Улсын бүртгэлийн салбарын	- Байгууллагын албан хаагчдын нийгмийн	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг

<p>албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор хөнгөлөлттэй нөхцлөөр албан хаагчдыг орон сууцтай болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>баталгааг хангах чиглэлээр Төрийн орон сууцны корпораци болон бусад холбогдох газартай хамтран ажиллаж, албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцтай болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p>	<p>хангах чиглэлээр Төрийн орон сууцны болон бусад холбогдох газартай хамтран ажиллаж, Төрийн орон сууцны корпорацийн “Буянт-Ухаа 2” орон сууцны хорооллыг ашиглалтанд ороход албан хаагчдыг хамруулахаар төлөвлөж байна.</p> <p>Төрийн орон сууцны корпорациас явуулж байгаа “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтод хөтөлбөрийн” хүрээнд аймаг тус бүрт 1000 айлын орон сууц төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаагаас Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Увс аймгийн Улаангом сум, Архангай аймгийн Эрдэнэбулган суманд тус тус баригдаж байгаа орон сууцнуудад тус газрын албан хаагчдыг хамруулах талаар судалж байна.</p> <p><b>Биелэлт: 30%</b></p>
<p>4.3.3. Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулна. 2015 он, жилдээ</p>	<p>-Эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулж, байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн оношлогоо, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амралт сувилалд хамруулах ажлыг эхлүүлж, эхний ээлжийн 15 албан хаагчийг сонгон сувилалд явуулсан.</p> <p>Албан хаагчдыг эрүүл мэндийн оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p><b>Биелэлт: 40%</b></p>
<p><b>4.4. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, сургалт, сурталчилгааны ажлыг боловсронгуй болгоно:</b></p>		
<p>4.4.1. Гадаадын 2-оос доошгүй орны ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай харилцаа холбоо хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан туршлага судална. 2015 он, жилдээ</p>	<p>-ОХУ-ын Хууль Зүйн яамны дэргэдэх Бүртгэлийн байгууллага болон бусад орны ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай харилцаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, уулзалт семинарт оролцоно.</p>	<p>НҮБ, Ази Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комиссоос хэрэгжүүлж буй Иргэний бүртгэл, хүн амын үндсэн статистик үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааг дэмжин ажиллах бүс нутгийн удирдах зөвлөлийн гишүүнээр тус газрын иргэний бүртгэлийн газрын даргыг, Монгол улсад дээрх үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх, зохицуулах ажлыг хариуцах мэдээлэгч төв болж ажиллахаар УБЕГ-ыг тус тус нэр дэвшүүлэн НҮБ-ын Статистикийн хэлтэст хүргүүлж Иргэний бүртгэлийн газрын дарга 2015-2019 онд бүс нутгийн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллахаар болсон.</p> <p>Бүс нутгийн удирдах зөвлөлийн гишүүдийн анхны хурал 2015 оны 7 дугаар сарын 28-30-ны өдрийн хооронд Тайланд Улсын Бангкок хотноо зохион байгуулагдахаар</p>

		<p>төлөвлөгдөж байна.</p> <p>Бүгд Найрамдах Турк Улсын “Хүн ам, иргэний бүртгэлийн ерөнхий газар”-тай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг боловсруулж Гадаад хэргийн ямаар дамжуулан хүргүүлээд байна.</p> <p>БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгын Компанийн бүртгэлийн байгууллагатай харилцаа холбоо тогтоох, цаашид хамтран ажиллах гэрээ байгуулах, туршлага солилцох хүсэлтийг Монгол Улсаас Хонконгт суугаа Ерөнхий консулаар дамжуулан холбогдох байгууллагад хүргүүлээд байна.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>4.4.2. Байгууллагын сургалтын нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг ерөнхий газрын нийт албан хаагчдын хэмжээнд зохион байгуулна.</p> <p>2015 он, жилдээ</p>	<p>-Байгууллагын 2015 оны сургалтын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангаж ажиллана.</p> <p>-Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.</p> <p>-Удирдах албан хаагчдын нэгдсэн сургалтыг зохион байгуулна.</p>	<p>УБЕГ-ын 2015 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 20 гаруй сургалт, семинарыг зохион байгуулж, давхардсан тоогоор 549 албан хаагчийг хамруулаад байна.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын “Удирдах албан хаагчдын нэгдсэн сургалт, семинар”-ыг 3 дугаар сард зохион байгуулсан.</p> <p><b>Биелэлт: 60%</b></p>
<p>4.4.3. Иргэдэд зориулсан сургалт, мэдээллийг улирал бүр тогтмол зохион байгуулж, хэвшүүлнэ.</p> <p>2015 он, жилдээ</p>	<p>-Иргэдэд зориулсан сургалт, мэдээллийг улирал бүр тогтмол зохион байгуулж, хэвшүүлнэ.</p>	<p>Улсын бүртгэлийн үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлах, иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай үндсэн ойлголт, төрлүүд, анхаарах асуудлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн ойлголт өгөх, тэдэнд төрийн үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангахад чиглэгдсэн сургалтыг “Сэргээн Засалт, Хөгжлийн Үндэсний төв”-д 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч, Сэргээн засалт, Хөгжлийн Үндэсний төвийн 30 орчим албан хаагчид хамрагдсан.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p><b>4.5. Гэмт хэрэг, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана:</b></p>		

<p>4.5.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана. 2015 он, жилдээ</p>	<p>- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>УБЕГ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын нийт албан хаагчдаас сургалтын хэрэгцээ шаардлага тодорхойлсон судалгаа авсны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдах хүсэлт гаргасан нийт 32 албан хаагчдыг 2015 оны 3 дугаар сарын 31-ний өдөр сургалтад хамруулсан.</p> <p>Энэхүү сургалтаар албан хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олж авахаас гадна ажлын байр, албан тушаалын гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн сургалт болсон.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>4.5.2. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана. 2015 он, жилдээ</p>	<p>-Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд УБЕГ-ын 2015 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны 2015 оны нэгдсэн сургалт, семинарт “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр Хүний эрхийн үндэсний комиссын холбогдох албан тушаалтныг урьж сургалт зохион байгуулсан.</p> <p>Хууль зүйн яаманд хүний эрхийн боловсрол, сургалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хүргүүлсэн.</p> <p><b>Биелэлт: 50%</b></p>
<p>4.5.3. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг хэрэгжүүлнэ. 2015 он, жилдээ</p>	<p>-Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль болон “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө /2013-2016/-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Хууль сахиулах байгууллагуудын Жендэрийн бодлого”, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн Үндэсний хороо, Эмэгтэй удирдагч сангийн хамтран зохион байгуулсан “Ажлын байран дахь бэлгийн дарамт” сэдэвт ёс зүйн семинар, сургалтад тус газрын холбогдох албан хаагчид хамрагдан ажиллаж байна.</p>

		<b>Биелэлт: 50%</b>
4.5.4.Терроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 2015 он, жилдээ	-Терроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулна.	Улсын бүртгэлийн ерөнхий аагсдүй терроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <b>Биелэлт: 50%</b>
4.5.5. Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана. 2015 он, жилдээ	-Авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Улсын бүртгэлийн ерөнхий аагсдүй 2015 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны 2015 нэгдсэн сургалт, семинарт “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтныг урьж сургалт зохион байгуулсан. <b>Биелэлт: 50%</b>
4.5.6. Албан тушаалтны 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гаргаж тайлагнана. 2015 он, жилдээ	- Албан тушаалтны 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. -Шинээр томилогдсон албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг тухай бүр авч ажиллана.	Тус газрын төрийн захиргааны нийт 1020 албан хаагчдаас 2014 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, <a href="http://www.meduuleg.iaac.mn">www.meduuleg.iaac.mn</a> сайтад бүртгүүлэн, 2013 оны ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг гаргаж Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Мөн төрийн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн иргэдээс хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, томилогдсон албан хаагчдаас “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг тухай бүр цаасан болон цахим хэлбэрээр гаргуулан авч, бүртгэн ажилласан. <b>Биелэлт: 70%</b>

/Төлөвлөгөөний биелэлтийн дундаж: жилийн хувьд 58.51%, эхний хагас жилийн хувьд 94.82%/

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР